

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бигэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/153/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: М.Атарцэцэг Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13.  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.24 № 85

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 18,990.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 366,304.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авч, 43,070.8 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 6 хөтөлбөр, 7 зорилт, 146 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 104 арга хэмжээг бүрэн, 5 арга хэмжээг 90.0 хувь, 16 арга хэмжээг 70.0 хувь, 12 арга хэмжээг 50.0 хувь, 2 арга хэмжээг 30.0 хувь буюу нийт дүнгээр 87.7 хувиар хэрэгжсэнээр тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0702900309

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	218,614.10	282,778.47
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,563,488.33	2,602,866.53
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,782,102.43</b>	<b>2,885,645.00</b>
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,782,102.43	2,885,645.00
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,782,102.43</b>	<b>2,885,645.00</b>
Үйл ажиллагааны орлогын дүн	1,816,790.07	1,062,863.71
Үйл ажиллагааны зардлын дүн	587,040.76	958,457.84
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>1,229,749.31</b>	<b>104,405.87</b>
Үйл ажиллагааны бус үр дүн	19,155,700.06	863,300.00
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(17,925.95)</b>	<b>(758.89)</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>	<b>2,782,102.43</b>	<b>2,885,645.00</b>
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,571,508.82	2,782,102.43
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
Тайлант оны үр дүн	1,210,593.61	103,542.57
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>2,782,102.43</b>	<b>2,885,645.00</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>	<b>969,819.98</b>	<b>1,448,056.89</b>
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	484,512.95	708,672.93
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	485,379.86	739,407.93
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>72,829.67</b>	<b>23,966.03</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(72,902.50)</b>	<b>(23,990.00)</b>
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>-</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>412,043.30</b>	<b>564,620.56</b>
Урсгал зардал	349,920.30	564,620.56
Хөрөнгийн зардал	62,123.00	-
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>411,631.67</b>	<b>564,056.51</b>
Улсын төсвөөс санхүүжих		
Орон нутгийн төсвөөс санхүүжих	<b>411,631.67</b>	<b>564,056.51</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 183,866.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Мөнгөн гүйлгээний тайлангийн орлогыг 3,660.0 мянган төгрөгөөр, зардлыг 79,375.7 мянган төгрөгөөр, санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 29,910.0 мянган төгрөгөөр, зардлыг 21,819.6 мянган төгрөгөөр, санхүүгийн байдлын тайлангийн бараа материалыг 6,143.0 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийг зардлыг 22,890.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй, нэмэлт санхүүжилтээр авсан 20,068.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардалд бичин тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 3,489.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 3,489.0 мянган төгрөгийн 1 зөрчил<sup>2</sup> илэрч 3,489.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

### 5.1 Албан шаардлага

1. Хантайшир 100 жилийн ойн арга хэмжээний 3,489.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын жолоочийн тооцооны хуудас бүрэн хөтлөгдөөгүй, тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн хөтлөн шатахууны зарцуулалтад хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Бигэр сумын Засаг даргын Тамгын газар	Мөнгөн гүйлгээний тайлангийн орлогыг 3,660.0 мянган төгрөгөөр, зардлыг 79,375.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	83,035.7	-	-	1	83,035.7	1	83,035.7	-	-	-	-
	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 29,910.0 мянган төгрөгөөр, зардлыг 21,819.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	51,729.6	-	-	1	51,729.6	1	51,729.6	-	-	-	-
	Санхүүгийн байдлын тайлангийн бараа материалыг 6,143.0 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийг зардлыг 22,890.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	29,033.0	-	-	1	29,033.0	1	29,033.0	-	-	-	-
	Нэмэлт санхүүжилтээр авсан 20,068.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардалд бичсэн.	1	20,068.0	-	-	1	20,068.0	1	20,068.0	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>4</b>	<b>183,866.3</b>	-	-	<b>4</b>	<b>183,866.3</b>	<b>4</b>	<b>183,866.3</b>	-	-	-	-

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
			4.00								

Бигэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бигэр сумын Засаг даргын тамгын газр	Хантайшир 100 жилийн ойн арга хэмжээний 3,489.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын жолоочийн тооцооны хуудас бүрэн хөтлөгдөөгүй, тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна	1	3,489.0	-	-	1	3,489.0	-	-	-	-
<b>Нийт</b>		<b>1</b>	<b>3,489.0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>3,489.0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Бигэр сумын Засаг даргын тамгын газар	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 556,462.3 мянган төгрөгийн 17, зарлагын 21,000.0 төгрөгийн 3, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 6,472.0 мянган төгрөгийн 7 шийдвэрийг мэдээлээгүй.	1	-	-	-	1	-	-	-	-	-
	Тайлант онд 18,990.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна	1	18,990.0	-	-	1	18,990.0	-	-	-	-
	Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 7,009.6 мянган төгрөгийн гүйлгээ байна	1	7,009.6	-	-	1	7,009.6	-	-	-	-
<b>Нийт</b>		<b>3</b>	<b>25,999.60</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>25,999.60</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>